

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН 2018 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 27-НЫ ӨДРИЙН ШУУРХАЙ
ЗӨВЛӨГӨӨНӨӨР ӨГЧ БУЙ ҮҮРЭГ ДААЛГАВАР

Үүрэг даалгавар-5: Байрны 1-р давхарт байрлах самбарт АТБӨЯХАТ-ийг төлнө үү гэсэн зарыг наах ажлыг яаралтай зохион байгуулах.

Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Ахмадын хотхоны 901, 902 дугаар байр, түр суурьших 813 дугаар байруудын мэдээллийн самбаруудын мэдээллийг шинэчлэн АТБӨЯХАТ-ийг төлнө үү гэсэн зурагт хуудсыг нийт 4 самбарт байршуулж оршин суугч иргэдийг тээврийн хэрэгслийн албан татвараа төлөх мэдээллээр хангах арга хэмжээг зохион байгууллаа.

(Зураг -1)



Үр дүн: Хотын Ерөнхий менежерийн шуурхайн биелэлтийг хангаж, оршин суугчдад татвар төлөх мэдээлэл хүргэсэн.

Үүрэг даалгавар-7: Хаврын тохижилт ногоон байгууламжийн ажил эхэлж байгаатай холбогдуулан батлагдсан зураг төсвийн дагуу тохижилтын ажлыг эхлүүлэх. Том модыг сэлгүүлэн суулгах ажлын шалгарсан ААНБ-уудтай гэрээг байгуулж, ажил эхлүүлэх.

Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Ахмадын хотхоны 901, 902 дугаар байрны гадна ногоон талбайд арчилгаа цэвэрлэгээ, усалгаа хийж зүлэг модыг сэргээн засах,, түр суурьших 813 дугаар байрны зүүн талд шинээр хайс хашлага хийж, мод суулгах 20 ширхэг нүх ухаж суулгац тарих бэлтгэл ажлыг 2018 оны 5 дугаар сарын 12-ны бүх нийтээр мод тарих үндэсний өдрөөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж, мод үрслүүлж худалдаалдаг “Навчит ой” ХХК-иас 1,5 метр өндөртэй шилжүүст мод худалдан авах гэрээ байгуулав.

(Зураг -2)



Үр дүн: Хотхоны 901, 902 дугаар байрны гадна орчны ногоон талбайг сэргээж түр суурьших 813 дугаар байрны гадна талбайг ногоон байгууламжтай болгов.

ХЯНАСАН:

ДУЛААНЫ ИНЖЕНЕР

Г.ЧУЛУУНБААТАР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН :

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

Г.БААТАРХҮҮ